



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Жаргалант үйлс” ХК-ийн нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчдээс Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, хувьцааг худалдан авах саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жаргалант үйлс” ХК-ийн нийт гаргасан 52,056 ширхэг хувьцааны 78,4 хувь буюу 40,806 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээдүүд болох “Жаргалтхаан хайрхан консалтинг” ХХК болон иргэн Г.Цагаач нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 21,6 хувь буюу 11,250 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1340 /нэг мянга гурван зуун дөчин/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Жаргалант үйлс” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Г.Цагаач/-д үүрэг болгосугай:

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000012